



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 562

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 15,668,646.63 (арван таван сая зургаан зуун жаран найман мянга зургаан зуун дөчин зургаан төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Ч.Цогоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001130

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дүгээр сарын 2-ны өдрийн
568 дугаар тогтоолын хавсралт

**"ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИАС "ХӨВСГӨЛ ДУЛААНЫ
СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Галын машин АЦ-40 (Зил 131) галын автоцистерн 59-04 УББ, 842172	1989.07.01	10,685,646.63	10,685,646.63	-
2	Суудлын автомашин Фургон УАЗ- 39094 81-34 УБЯ, 30151846	2003.04.30	4,983,000.00	4,983,000.00	-
Нийт			15,668,646.63	15,668,646.63	-
Нийт дүн			(Арван таван сая зургаан зуун жаран найман мянга зургаан зуун дөчин зургаан төгрөг жаран гурван мөнгө)		-